

**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2015 оны 04 дугаар
сарын 29 -ны өдөр

Дугаар 01

Багануур

Хурлын ирцийн тухай

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 20,974,360 ширхэг хувьцаа эзэмшигчдээс брокерын пүүсүүдээр дамжуулан хуралд оролцох санал ирээгүй, 15,730,770 ширхэг хувьцааг төлөөлж “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 3 хүн итгэмжлэлээр, 572 ширхэг хувьцааг эзэмшигч 2 хүн өөрийн биеээр, нийт 15,731,342 хувьцааг эзэмшигч 3 хувь нийлүүлэгч оролцож хурал 75,003 % ирцтэй байна. / Бүртгэлийг хавсаргав/

1. “Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц бүрдсэн тул хурлыг нээхийг зөвшөөрсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИСС:

ДАРГА
ГИШҮҮД



Д.ТҮВШИНТӨГС
Д.ДАВААДАШ
Б.НАРАНЦЭЦЭГ



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 01

Багануур

Дүгнэлт батлах тухай

“Компанийн тухай” Монгол улсын хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Багануур Хувьцаат Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хоёр. Компанийн алдагдлыг 2015 онд бууруулж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  /Б.ЖАВХЛАН/



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны *04* дүгээр
сарын *29* ний өдөр

Дугаар *00*

Багануур

Компанийн 2014 оны санхүүгийн тайлангийн тухай


“Компанийн тухай” Монгол улсын хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. “Багануур” ХК-ийн 2014 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг хүлээн зөвшөөрсүгэй.

Хоёр. Санхүүгийн тайлан, дүгнэлтийн талаар холбогдох хууль тогтоомжийн дагуу нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /М.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.ЖАВХЛАН



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны ~~04~~ дүгээр
сарын ~~29~~ ний өдөр

Дугаар *03*

Багануур


Аудитын хорооны дүгнэлтийн тухай

“Компанийн тухай” Монгол улсын хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлж, компанийн санхүүгийн чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Аудитын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



/Б.ЖАВХЛАН/



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 04

Багануур

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
ажлын тайлан, цалингийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.14 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг 2015 оны 05 дугаар сарын 01-ээс эхлэн өөрчлөн тогтоож, хавсралтаар баталсугай.

Гурав. Компанийн 2015 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээг тухай бүрт авч ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



/Б.ЖАВХЛАН/



Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 04 дүгээр сарын
29-ний өдрийн *04* тоот тогтоолын хавсралт

Багануур ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн 2015 оны цалингийн өөрчлөлтийн төсөв

№	ТУЗ-ийн бүрэлдэхүүн	орон тоо	2015 оны эхний 4 сар		Өөрчлөн тогтоох цалингийн санал		
			Сар	бүгд	Орон тоо	Сар төг	бүгд төг
1	ТУЗ-ийн дарга	1	450000	450000	1	650000	650,000
2	Төрийн төлөөлөл энгийн гишүүд	5	380000	2660000	3	550000	1,650,000
3	Хараат бус энгийн гишүүн	5	380000	1140000	4	550000	2,200,000
4	Хороодын даргын сонгуультай гишүүд				3	600000	1,800,000
5	Компанийн хувьцааны 21%-ийг эзэмшигчийн төлөөлөл	2			2	550000	1,100,000
	бүгд	13		4250000	13		7,400,000
6	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	380000	380000	1	550000	550000
	НИЙТ	14		4630000			7.950,000

"БАГАНУУР" ХК-ИЙН АРХИВ
ХУУЛГАР ҮНЭН
Эрхлэгч: *Б.О.Орво*
20 *04* сар *29* өдөр

**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны 04 дүгээр
сарын 01 ний өдөр

Дугаар 05

Багануур

Компанийн дүрэмд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

“Компанийн тухай” Монгол улсын хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. “Багануур” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3.7 дахь “Тухайн санхүүгийн жилийн 11 дүгээр сард Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан, хурлыг тухайн санхүүгийн жилд багтаан хуралдуулж, Компанийн ирэх санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батална” гэсэн заалтыг хүчингүй болгон, 10 дугаар зүйлийн 10.3.2 дахь “Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан Компанийн бизнес төлөвлөгөө, төсвийн төслийг хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах” гэсэн заалтыг “Гүйцэтгэх удирдлагаас боловсруулсан Компанийн санхүүгийн жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах” гэж өөрчилсүгэй.

Хоёр. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, мөрдөн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.ЖАВХЛАН/



**“БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2015 оны *04* дүгээр
сарын *22* ний өдөр

Дугаар *06*

Багануур


Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

“Компанийн тухай” Монгол улсын хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, Тооллогын комиссын 06, 07 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Багануур Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг хэрэгжүүлэх Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг нэгдүгээр хавсралтаар, хараат бус гишүүдийг хоёрдугаар хавсралтаар тус тус сонгон баталсугай..

ХУРЛЫН ДАРГА

Б.ЖАВХЛАН






Төлөөлөн удирдах зөвлөлийн
2015 оны 04 дүгээр сарын 19-ны
өдрийн 06 тоот тогтоолын 1-р хавсралт

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн:

1. Б.Ариунболд-"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Тэргүүн дэд захирал
2. Д.Болд--"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Бодлого төсөл хөтөлбөр хариуцсан захирал
3. М.Хуягбаатар- "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Засгийн газартай харилцах менежер
4. Г.Мэргэнбаяр-Эрчим хүчний яамны Эрчим хүчний хөгжлийн төвийн дэд захирал
5. Д.Нарангэрэл-Төрийн өмчийн хорооны ахлах мэргэжилтэн
6. Д.Артаг-Уул уурхайн яамны төрийн нарийн бичгийн дарга
7. Л.Оюунчимэг-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын хэлтсийн дарга
8. Г.Батдорж-"Хөтөл цемент шохой" ХХК-ийн гүйцэтгэх захирал
9. О.Болор-Эрдэнэ-Дархан төмөрлөгийн үйлдвэр ХК-ийн Уул уурхай хариуцсан дэд захирал

1





Төлөөлөн удирдах зөвлөлийн
..... оны 04 дүгээр сарын 06-ны
өдрийн 06 тоот тогтоолын 2-р хавсралт

Хараат бус гишүүн:

1. Г.Ёндонгомбо-Эрчмийн аж үйлдвэрийн хөгжлийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирал
2. Т.Наран-Нүүрс ассоциацийн тэргүүн
3. Б.Осоргарав-Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал
4. Б.Ганбат-Lexloci ХХК-ийн өмгөөлөгч

"БАГАНУУР" ХК-ИЙН АРХИВ
ХУУЛГАР ИЭН
Суртал: *Б. Ганбат*
20 05 17